

## **ГАДААДЫН ИРГЭДИЙГ СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль /цаашид ХИС гэх/-д гадаадын иргэнийг оюутнаар элсүүлэн суралцуулахад энэхүү журмыг баримтлана.
- 1.2. Энэхүү журам нь Монгол Улсын Боловсролын тухай хууль, БСШУ-ны сайдын 2001 оны 113 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсын Дээд боловсролын байгуулагуудад гадаадын иргэдийг суралцуулах журам, ХИС-ийн дүрэм, дотоод журмыг үндэслэнэ.
- 1.3. ХИС-д суралцах, мэргэжил дээшлүүлэх гадаадын иргэн нь /цаашид “суралцахыг хүсэгч” гэх/ Монгол Улсад мөрдөгдөж буй боловсролын агуулгын түвшин, стандарттай дүйцэх өмнөх шатны боловсрол эзэмшсэн байвал зохино.

### **ХОЁР. ЭЛСЭЛТ**

- 2.1. Гадаадын иргэнийг оюутнаар элсүүлэн суралцуулах асуудлыг гадаад харилцааны алба /ГХА/, сургалт, судалгааны хөгжил, аудитын үйлчилгээний алба /ССХАҮА/, Эрдмийн сургууль /ЭС/ хариуцан ажиллана. Бүх шатны сургалтын элсэлтийг **жил бүрийн 5 дугаар сарын 1-нээс 20, магистрантур, докторантурын элсэлтийг 1 дүгээр сарын 1-нээс 20, 9 дүгээр сарын 1-нээс 15-ны хооронд зохион байгуулна.** Элсэлтийн шалгалт нь Монгол хэлний ярианы болон бичгийн шалгалт, мэргэжлийн шалгалтуудаас бүрдэнэ.
- 2.2. Суралцахыг хүсэгч нь элсэн суралцах анкетийг тус сургуулиас батлан гаргасан “ХИС-д суралцахыг хүссэн гадаадын иргэний өргөдөл” маягтын дагуу бэлтгэж ГХА-нд ирүүлнэ. Өргөдөлд дор дурдсан материалыг хавсаргасан байна.
  - Хувийн өргөдөл
  - Гадаад паспортын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /3-аас дээш жилийн хүчинтэй хугацаатай байх/
  - Бүрэн дунд боловсролын үнэмлэх /эх хувь, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, монгол хэлнээ хөрвүүлж нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны хуулбар /
  - Бүх шатны боловсролын баримт бичиг /эх хувь, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, монгол хэлнээ хөрвүүлж нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны баталгаа/
  - Хэрвээ байгууллагын нэр дээр суралцах гэж буй бол тухайн иргэнийг Монгол улсад суралцахаар илгээж буй байгууллагын тодорхойлолт /Албан ёсоор баталгаажиж Монгол Улсын Гадаад харилцааны яамаар дамжуулж авсан байх/
  - Эрүүл мэндийн бичиг /ХДХВ/ДОХ-ын шинжилгээний бичиг/
  - 3x4 хэмжээний 8 хувь зураг /Сүүлийн 6 сарын хугацаанд авахуулсан байх/
  - Элсэлтийн хураамж
- 2.3. Гадаад харилцааны алба материалыг хүлээн авч хянаад шаардлага хангасан нөхцөлд СТМА-д танилцуулна. СТМА, Эрдмийн сургууль элсэлтийн шалгалтыг

зохион байгуулж, элсэлтийн шалгалт өгөх зөвшөөрлийн хуудас олгож шалгалт авна. Шалгалтад тэнцсэн тохиолдолд тус сургуульд суралцах эрхийн бичиг олгоно.

2.4. Суралцахыг хүсэгч нь Монгол хэлний ярианы болон бичгийн шалгалтаар мэдлэгийн түвшин нь дундаас доош гэж дүгнэгдсэн тохиолдолд тухайн жилийн хичээл эхлэхээс өмнө 45 хоногийн Монгол хэлний төлбөртэй сургалтад хамрагдана.

2.5. Тус сургуульд суралцах эрхийн бичиг олгогдсон суралцахыг хүсэгчийг ХИС-ийн захиралд танилцуулж суралцагчтай ГХА-ны дарга, харъяалах сургуулийн захиралтай гэрээ байгуулна. Гэрээ нь тус сургуулиас батлан гаргасан загварт үндэслэгдсэн байна.

2.6. Суралцагч Гадаад оюутантай байгуулсан гэрээнд заасны дагуу сургалтын төлбөр, үйлчилгээний хураамжийг бүрэн төлж баримтыг хуулбарын хамт ГХХАГ-т тушаана.

2.7. Суралцагчийг Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн тухай хууль, дүрэм, журамд заасны дагуу эрүүл мэндийн даатгалд даатгуулна. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суралцагч өөрөө хариуцана. Суралцагчийг эрүүл мэндийн даатгалд даатгуулах үүргийг харъяалах сургуулийн захирал хүлээнэ.

2.8. Суралцагчийн хүсэлтээр ХИС өөрийн оюутны дотуур байранд орох тохиолдолд гэрээ хийж, төлбөртэйгөөр суулгана. Оюутны дотуур байрны ачаалал болон бусад шалтгаанаар ХИС-ийн оюутны дотуур байранд суугаагүй суралцагчид амьдрах байр, орон сууцаа олоход нь туслалцаа үзүүлнэ. Байр, орон сууц худалдан авах, хөлслөх зардлыг суралцагч өөрөө хариуцна.

### **ГУРАВ. ВИЗ, ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ**

3.1. Гадаад харилцааны алба нь бүрдүүлсэн материал, суралцах эрхийн бичиг, суралцагчтай байгуулсан гэрээ, сургалтын төлбөрийн баримтыг үндэслэн тухайн суралцагчийн тус сургуульд суралцах эрхийн “S” ангиллаар орж ирэх зөвшөөрөл олгох хүсэлтийг БШУЯ, Гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх газарт /ГИХАЭГ/ гаргана. Хүсэлтийн дагуу олгосон зөвшөөрлийг ГИХАЭГ-аар дамжуулан элсэгчийн харъяаллын консулын газарт явуулна.

3.2. Суралцагч харъяа консулын газраас “S” ангиллын виз авч Монгол улсад ирэх бөгөөд ирснээс хойш 2 өдрийн дотор тус сургуулийн Гадаад харилцааны албанд бүртгүүлж, 7 хоногийн дотор ГИХАЭГ-т бүртгүүлнэ.

3.3. Монгол Улсад орж ирснээс хойш 21 хоногийн дотор сургуулийн захирлын зөвшөөрлийн дагуу БСШУЯ, ГИХАЭГ-аас Монгол Улсад жилээр оршин суух зөвшөөрөл авна.

#### ***БШУЯ-наас оршин суух зөвшөөрөл авахад суралцагчийн бүрдүүлэх материалын жагсаалт***

- БШУЯ-нд хандсан албан бичиг /Сургуулийн суралцагчид оршин суух зөвшөөрөл хүссэн/
- Сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн /гэрчилгээний/ нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Суралцагчаас элсэх шалгалт авч тэнцсэн тухай баталгаажсан баримт

- Суралцагчийн эрүүл мэндийн бичиг /ХДХВ/ДОХ-ын шинжилгээний бичиг/
- Суралцагчийн паспортын хуулбар /S ангиллын визтэй хуудасны хамт/
- Зөвшөөрлийн хураамж 3000 төгрөг

**ГИХАЭГ-аас оршин суух зөвшөөрөл авахад суралцагчийн бүрдүүлэх материалын жагсаалт**

- БШУЯ-аас олгох суралцах зөвшөөрөл
- Сургуулийн оршин суух зөвшөөрөл хүссэн албан бичиг
- Оршин суугаа засаг захиргааны тодорхойлолт
- Хүчин төгөлдөр паспорт
- Цээж зураг авахуулж хурууны хээгээ баталгаажуулсан байх
- Зөвшөөрлийн хураамж /хураамжийн үнийг тухайн үеийн үнэлгээгээр тогтооно/. **Одоо: шинээр авахад зөвшөөрлийн 41000 төгрөг+үнэмлэхний 17700 төгрөг төлнө.**
- Оршин суугчийн анкет /үнийг тухайн үеийн үнэлгээгээр тогтооно/. **Одоо: 2000 төгрөг**

### **ДӨРӨВ. СУРГАЛТ**

4.1. БШУЯ, ГИХАЭГ, ГХЯ-ны зохих зөвшөөрлийн дагуу Монгол улсад орж ирсэн суралцагчийг ГХА-аассуралцах сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгчид танилцуулна.

4.2. Суралцагчийн харъяалан суралцах сургууль, тэнхим нь ХИС-ийн дүрэм, журам, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу чанартай үйлчилгээ үзүүлэх асуудлыг хариуцна.

4.3. Сургалтын үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдлоо суралцагч харъяалах бүрэлдэхүүн сургуулийн тэнхимийн эрхлэгч, захиралд гаргах бөгөөд харъяалах сургуулийн захирлын эрх хэмжээнд шийдвэрлэгдэх боломжгүй бол ХИС-ийн захиралд тавьж шийдвэрлүүлнэ.

4.4. Суралцагч нэг хичээлийн жилд хоёр удаа буюу оюутны өвлийн болон зуны амралтаар өөрийн нутагтаа явах эрхтэй. Амралтаараа нутаг явахдаа суралцагч нь чөлөө олгохыг хүссэн өргөдөл, чөлөө олгохыг зөвшөөрсөн бүрэлдэхүүн сургуулийн захирал, албаны даргын гарын үсэг, суралцаж дууссан семестрийн дүнгийн жагсаалтын хамт Гадаад харилцааны албанд хүсэлт гаргах бөгөөд өргөдөл гаргаснаас 7-14 хоногийн дотор ГИХАЭГ-т хандсан гарах орох визний албан бичгийг хийж өгнө.

4.5. “S” ангиллын виз бүхий суралцагч нь 90 хүртэлх хоногийн гарах орох визийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хэтрүүлсэн тохиолдолд нэг жилийн ахин “S” ангиллын визний урилга явуулахгүй бөгөөд оюутантай байгуулсан “Оюутан суралцуулах гэрээ”-г цуцлах үндэслэл болно.

4.6. Суралцагч оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө Гадаад харилцааны албанд мэдэгдэж зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах материалыг бүрдүүлж өгнө. Хэрэв суралцагч хүндэтгэн үзэх шалтгаанаар визний хугацааг хэтрүүлэх тохиолдолд холбогдох баримтаа өргөдлийн хамт хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө тус сургуульд захидал, албан бичиг, факсаар мэдэгдсэн байна.

4.7. Суралцагч энэхүү журмын 4.4 дэх хэсэгт заасан үндэслэлээс бусад гэнэтийн болон ар гэрийн гачигдал, судалгаа хийх зорилгоор хичээлийн дундуур нутаг буцах тохиолдолд үндэслэл бүхий өргөдөл гарган мэргэжлийн багш, тэнхим, сургуулийн зөвшөөрлийг авсан байна. Энэ тохиолдолд сургалцагчид нэг жилийн чөлөө олгоно.

4.8. Суралцагч нь тухайн хичээлийн жилд сургуулийн Удирдах зөвлөлөөс тогтоосон сургалтын төлбөрийг хичээл эхлэхээс 14 хоногийн өмнө тус сургуулийн харилцах дансанд тушааж, баримтыг хуулбарын хамт Гадаад харилцааны албанд өгснөөр сургалтанд хамрагдах, номын сангаар үйлчлүүлэх болон бусад үйлчилгээ авах эрх нь нээгдэнэ.

4.9. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгаснаас гадуур өөрийн хүсэл сонирхлоор хөдөө орон нутагт болон бусад газарт зорчсонтой холбогдон үүсэх аливаа харилцаанаас бий болох хариуцлагыг суралцагч өөрөө хүлээнэ.

### **ТАВ. СУРАЛЦАГЧИЙГ ЧӨЛӨӨЛӨХ, ШИЛЖҮҮЛЭХ, ХАСАХ**

5.1. Суралцагчийн өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдөх болон бусад сургуульд шилжин суралцах хүсэлтийг хэлэлцэн зөвшөөрсөн бүрэлдэхүүний сургуулийн саналыг үндэслэн ХИС-ийн захирлын тушаалаар түүнийг сургуулиас чөлөөлж БШУЯ, ГИХАЭГ-аас олгосон оршин суух зөвшөөрлийг хасуулж холбогдох зардлыг суралцагчаар гаргуулна.

5.2. Суралцагч өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдөх тохиолдолд хариуцсан сургуулийн сургалтын мэргэжилтний тодорхойлолт, захирлын тушаалыг үндэслэн судлаагүй үлдсэн хичээлийн багц цагийн төлбөрийг Санхүүгийн албанаас буцаан олгоно.

5.3. Суралцагч Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зүйл, заалт, энэхүү журмын 4-р зүйлийн 4.6, 4.7 дахь хэсгийг зөрчсөн, оюутан суралцуулах тухай гэрээний сургуулиас хасах үндэслэл бүхий зүйл заалтыг зөрчсөн бол ХИС-ийн захирлын тушаалаар сургуулиас хасч БШУЯ, ГИХАЭГ-аас олгосон оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгуулна.

5.4. Суралцагч энэхүү журмын 5.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр сургуулиас хасагдсан тохиолд түүний судлаагүй үлдсэн хичээлийн цагийн төлбөрийг буцан олгохгүй.

### **ЗУРГАА. ТӨГСӨЛТ**

6.1. Бакалаврын суралцагч 4 жил, магистрантурын суралцагч 1.5-2 жил, докторантурын суралцагч 3 жил суралцсан байна.

6.2. Тухайн мэргэжлээр сургалтын төлөвлөгөөний дагуу суралцаж, сургалтын агуулгыг бүрэн эзэмшиж, зохих үнэлгээ авч төгсөж буй гадаадын төгсөгчийн дипломыг судласан кредит цагийг илтгэсэн хавсралтын хамт англи, монгол хэл дээр үйлдэж олгоно.

6.3. Суралцагчийн кредит цагийн тооцоо, үнэлгээ, дипломын дүнг нэгтгэн гаргах ажлыг тухайн салбар сургууль, сургалтын алба, сургуулийн захирал баталгаажуулна.

6.4. Суралцах хугацаандаа сургалтын төлөвлөгөөний дагуу хичээлийн хөтөлбөрөө бүрэн судалж дуусгаагүй болон зэрэг хамгаалж чадаагүйн улмаас оршин суух хугацааг сунгах тохиолдолд суралцагч нэмж нэг жилийн сургалтын төлбөр төлнө.

6.5. Төгсөгчид Гадаад харилцааны албанаас олгох тойрох хуудсаар сургуультай тооцоо хийж диплом гардуулах өдрөөс 7 хоногийн өмнө СТМА-нд өгнө.

### **ДОЛОО. ХАРИУЦЛАГА**

7.1. Суралцагч Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зүйл, заалт, энэхүү журмын 4-р зүйлийн 4.6, 4.7 дахь хэсгийг зөрчсөн, оюутан суралцуулах тухай гэрээний сургуулиас хасах үндэслэл бүхий зүйл заалтыг зөрчсөн бол ХИС-ийн захирлын тушаалаар сургуулиас хасч БСШУЯ, ГИХАЭГ-аас олгосон оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгуулна.

7.2. Энэхүү журмын 7.1-дэх хэсэгт заасан зөрчлөөс бусад зүйл заалтыг зөрчсөн суралцагч нарт эхний удаад сануулж, 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд сургуулиас хасах хүртэлх арга хэмжээ авна.